



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 04 сарын 01 өдөр

Дугаар 1/189

Чингис хот

Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх,
хамгаалах ажилд хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.13, Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.7, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.5, Улсын онцгой комиссын 2020 оны 01 дүгээр албан даалгаврыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд хуурайшилтын зэрэглэл өндөр байгаатай холбогдуулан ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах ажилд шаардлагатай 16000000 /арван зургаан сая/ төгрөгийн хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн гамшигтай тэмцэх зардлаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /С.Нямдаваа/-д зөвшөөрсүгэй.

2. Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах ажлын төсвийн задаргааг хавсралтаар баталсугай.

3. Экспедицийн бэлтгэл, бэлэн байдлыг хангаж шаардлагатай үед цаг агаарт зориудаар нөлөөлж хур тунадас оруулах ажлыг зохион байгуулахыг Ус цаг уур орчны шинжилгээний төв /Л.Чулуун/-д даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч, Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах зөвлөлийн дарга /Г.Хэрлэнчулуун/-д, Онцгой байдлын газрын дарга /дэд хурандаа Ж.Эрдэнэбат/-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

211010497

Аймгийн Засаг даргын 2020 оны
04 дугаар сарын 01 өдрийн А/189
дугаар захирамжийн хавсралт

Зардлын тооцоо

№	Зарцуулах ажил	Төсөв / төгрөг /	Хэрэгжүүлэгч байгууллага
1	Хэрлэн сумын 1-6 дугаар багийн айл өрхүүдийн эгнээ хоорондор хамхуул өвсийг аюулгүй болгох зардал	5.000.000	Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газар
2	Ой, хээрийн түймрийн эрсдэл бүхий сумдад шуурхай бүлэг ажиллуулах зардал	2.500.000	Онцгой байдлын газар
3	Цаг агаарт зориудаар нөлөөлөх ажлын томилолт, шатахууны зардал	8.500.000	Ус цаг уур орчны, шинжилгээний газар
Нийт		16.000.000	